

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/24/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Аудитор: С.Алтанхуяг Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:Altankhuyags@audit.gov.mn">Altankhuyags@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ий захирал Ж.Баяртуул Утас: 99066015 Цахим хаяг: <a href="mailto:platinumprogressaudit@gmail.com">platinumprogressaudit@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.1 Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт .....	14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Албан шаардлага .....	20
5.2 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭСЯ	Элчин сайдын яам
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/633  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.ХАЛИУН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь Чин Ван Ханддоржийн өргөөний өв соёлыг алдагдуулахгүйгээр хоёр гэрт 142.8 сая төгрөгийн их засварын ажил хийж, хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай” тогтоолын дагуу тус үйлдвэрийн газар тайлант онд 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас 26.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## Бусад асуудал

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамаараагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц.НАРАНЧИМЭГ*



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,099,584,580.47	1,872,113,173.14
1.1.2	Дансны авлага	100,308,161.10	159,613,084.23
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	61,161,668.19	309,060.28
1.1.4	Бусад авлага	283,679,932.00	237,377,154.38
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	2,250,000,000.00	4,000,000,000.00
1.1.6	Бараа материал	569,578,469.71	602,644,511.61
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	9,460,334.96	9,650,802.06
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,373,773,146.43</b>	<b>6,881,707,785.70</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	21,916,837,175.76	20,762,152,370.57
1.2.2	Биет бус хөрөнгө	13,485,345,964.78	13,481,743,691.98
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>35,402,183,140.54</b>	<b>34,243,896,062.55</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,775,956,286.97</b>	<b>41,125,603,848.25</b>
2	Өр төлбөр эзэмшигчдийн өмч	-	-
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	9,902,243.00	-
2.1.1.3	Татварын өр	33,042,218.21	71,898,352.94
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,050,000.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,466,250.00	102,229,400.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>54,460,711.21</b>	<b>174,127,752.94</b>
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	587,440,207.54	559,834,341.67
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>587,440,207.54</b>	<b>559,834,341.67</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>641,900,918.75</b>	<b>733,962,094.61</b>
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: -төрийн	15,103,851,256.35	15,103,851,256.35
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	-Хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13,194,081,634.73	12,816,270,201.75
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	12,836,122,477.14	12,471,520,295.54
<b>2.3.10</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>41,134,055,368.22</b>	<b>40,391,641,753.64</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>41,775,956,286.97</b>	<b>41,125,603,848.25</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,268,681,655.98	9,173,038,916.30
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,100,190,991.38	3,910,662,398.93
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(831,509,335.40)</b>	<b>5,262,376,517.37</b>
4	Түрээсийн орлого	3,069,692,327.37	-
5	Хүүний орлого	623,272,401.75	716,210,877.29
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	21,866,498.26	17,823,799.36
9	Борлуулалт маркетингийн зардал	4,146,439.10	2,110,000.00
<b>10</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	<b>2,658,769,145.82</b>	<b>5,596,528,880.81</b>
11	Санхүүгийн зардал	9,235,633.72	-
12	Бусад зардал	144,263,222.50	216,036,131.51
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,203,930.27	13,141,205.83
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>68,111,384.11</b>	<b>194,877,387.53</b>
19	Орлогын татварын зардал	15,813,686.49	73,502,960.61
20	Татварын дараах ашиг (алдагдал)	52,297,697.62	121,374,426.92
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>52,297,697.62</b>	<b>121,374,426.92</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>52,297,697.62</b>	<b>121,374,426.92</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
<b>2023 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>15,103,851,256.35</b>	<b>8,895,715,168.76</b>	<b>12,812,944,830.49</b>	<b>36,812,511,255.60</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	60,992,939.03	<b>60,922,939.03</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>15,103,851,256.35</b>	<b>8,895,715,168.76</b>	<b>12,873,867,769.52</b>	<b>36,873,434,194.63</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	52,297,697.62	<b>52,297,697.62</b>
Зарлагдсан ногдол ашиг	-	-	(90,042,990.00)	<b>(90,042,990.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	4,298,366,465.97	-	<b>4,298,366,465.97</b>
<b>2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>15,103,851,256.35</b>	<b>13,194,081,634.73</b>	<b>12,836,122,477.14</b>	<b>41,134,055,368.22</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(459,827,759.52)	<b>(459,827,759.52)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>15,103,851,256.35</b>	<b>13,194,081,634.73</b>	<b>12,376,294,717.62</b>	<b>40,674,227,608.70</b>
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	121,374,426.92	<b>121,374,426.92</b>
Зарлагдсан ногдол ашиг	-	-	(26,148,849.00)	<b>(26,148,849.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(377,811,432.98)	-	<b>(377,811,432.98)</b>
<b>2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>15,103,851,256.35</b>	<b>12,816,270,201.75</b>	<b>12,471,520,295.54</b>	<b>40,391,641,753.64</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>10,023,115,892.52</b>	<b>10,247,049,124.75</b>
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан орлого	11,384,584.00	15,576,976.80
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,923,951,300.01	10,207,685,765.46
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,087,780,008.51	23,786,382.49
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага</b>	<b>7,795,045,016.51</b>	<b>9,834,842,232.94</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,320,599,232.60	3,519,741,896.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	676,521,994.60	1,025,996,057.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	870,424,908.56	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,295,340,259.06	2,867,658,330.28
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	376,200,318.29	271,457,910.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	675,737,406.51	44,333,290.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	25,466,969.89	685,540,971.30
1.2.9	Бусад мөнгөн зарлага	554,753,927.00	1,420,113,776.76
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,228,070,876.01</b>	<b>412,206,891.81</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>588,157,881.20</b>	<b>716,190,285.97</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	27,200,000.00	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Түрээсийн орлого	-	-
2.1.6	Хүүгийн орлого	560,957,881.20	716,190,285.97
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,772,834,334.00</b>	<b>2,343,023,876.45</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	764,969,334.00	521,413,397.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,865,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	2,000,000,000.00	1,821,610,479.45
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,184,676,452.80)</b>	<b>(1,626,833,590.48)</b>
<b>3</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3.1.2	Хувьцаа болон өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	90,042,990.00	26,148,849.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	90,042,990.00	26,148,849.00
3.2.1	Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	(90,042,990.00)	(26,148,849.00)
<b>4.1</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	(7,348,810.85)	13,304,140.34
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(53,997,377.64)	(1,227,471,407.33)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	3,153,581,958.11	3,099,584,580.47
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	3,099,584,580.47	1,872,113,173.14

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц-2025гүйц	2025 гүйц/2024 гүйц	2025 төл-2025 гүйц	2025гүйц/2025 төл
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол нэр төрлөөр:</i>									
1	1.1 Үйлчилгээ, ашиглалтын орлого	мян/төг	2,992,348.0	3,941,015.6	4,027,839.3	1,035,491.3	134.6	(86,823.7)	102.2
	1.2 ЭСЯ-уудын түрээсийн орлого	мян/төг	2,487,960.8	3,001,134.3	2,583,691.6	95,730.9	103.8	417,442.7	86.1
	1.3 Зоогийн үйлчилгээний орлого	мян/төг	601,806.4	742,193.1	907,078.6	305,272.2	150.7	(164,885.5)	122.2
	1.4 Автобаазын орлого	мян/төг	380,178.9	507,867.9	656,623.9	276,445.0	172.7	(148,756.0)	129.3
	1.5 Бусад түрээсийн орлого	мян/төг	581,731.5	1,550,452.7	985,824.9	404,093.3	169.5	564,627.8	63.6
	1.6 Бусад орлого	мян/төг	940,691.2	713,000.0	759,156.5	(181,534.7)	80.7	(46,156.5)	106.5
2	<b>Нийт орлого</b>	мян/төг	<b>7,984,716.8</b>	<b>10,455,663.6</b>	<b>9,920,214.8</b>	<b>1,935,498.0</b>	<b>124.2</b>	<b>535,448.8</b>	94.9
3	<b>Нийт зардал</b>	мян/төг	<b>7,916,605.4</b>	<b>10,324,484.4</b>	<b>9,725,337.4</b>	<b>1,808,732.0</b>	<b>122.8</b>	<b>599,147.0</b>	94.2
	Үүнээс: удирдлагын зардал	мян/төг	1,221,774.2	1,599,130.0	1,656,893.6	435,119.4	135.6	(57,763.6)	103.6
4	Татварын өмнөх ашиг	мян/төг	68,111.4	131,179.2	194,877.4	126,766.0	286.1	(63,698.2)	148.6
5	Цэвэр ашиг/алдагдал	мян/төг	52,297.7	118,061.3	175,389.6	123,091.9	335.4	(57,328.4)	148.6
6	<b><u>төсвийн төлбөрт нийт дүн</u></b>	<b>мян/төг</b>	<b>1,511,133.9</b>	<b>2,011,446.9</b>	<b>2,524,921.1</b>	<b>1,013,787.2</b>	<b>167.1</b>	<b>(513,474.2)</b>	125.5
	а/ Орлогын албан татварт	мян/төг	15,813.7	11,746.6	89,550.9	73,737.2	566.3	(77,804.2)	762.4
	б/ НӨАТатвар	мян/төг	379,672.0	381,000.0	904,008.3	524,336.3	238.1	(523,008.3)	237.3
	в/Ус ашигласны төлбөр		7,699.0	8,400.0	4,780.2	(2,918.8)	62.1	3,619.8	56.9
	г/ НДШ	мян/төг	673,563.3	1,023,349.8	1,028,953.6	355,390.3	152.8	(5,603.8)	100.5
	д/ Хувь хүний орлогын татвар	мян/төг	217,464.4	226,061.0	272,309.7	54,845.3	125.2	(46,248.7)	120.5
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян/төг	5,059.0	10,118.7	16,517.6	11,458.6	326.5	(6,398.9)	163.2
	ё/ Бусад татвар	мян/төг	79,464.0	40,680.3	23,422.9	(56,041.1)	29.5	17,257.4	57.6
	НХАТ	мян/төг	14,397.0	12,000.0		(14,397.0)	-	12,000.0	-
	Газрын төлбөр	мян/төг	65,068.0	28,680.3	23,422.9	(41,645.1)	36.0	5,257.4	81.7
	ж/ Түрээсийн орлогоос төвлөрүүлэх	мян/төг	132,398.0	310,090.5	185,378.0	52,980.0	140.0	124,712.5	59.8
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян/төг	90,043.0	58,733.2	26,148.8	(63,894.2)	29.0	32,584.3	44.5
8	Нийт ажилтаны тоо	хүн	157.0	165.0	142.0	(15.0)	90.4	23.0	86.1

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

9	Нийт цалингийн сан	мян/төг	2,842,931.0	4,263,957.5	4,258,928.7	1,415,997.7	149.8	5,028.7	99.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян/төг	1,509.0	2,153.5	2,499.4	990.4	165.6	(345.9)	116.1
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.99	0.99	0.98	(0.0)	98.9	0.0	99.3
12	Хөрөнгө оруулалт	мян/төг	782,737.0	627,014.5	558,735.1	(224,001.9)	71.4	68,279.4	89.1
13	Нийт авлага	мян/төг	445,150.0	450,000.0	397,299.3	(47,850.7)	89.3	52,700.7	88.3
	Үүнээс:Найдваргүй авлага	мян/төг	22,701.0	20,000.0	5,949.5	(16,751.5)	26.2	14,050.5	29.7
14	Нийт өглөг	мян/төг	641,901.0	771,809.6	733,962.1	92,061.1	114.3	37,847.5	95.1
	Богино хугацаат өр төлбөр	мян/төг	54,461.0	129,204.4	174,127.8	119,666.8	319.7	(44,923.4)	134.8
	Урт хугацаат өр төлбөр	мян/төг	587,440.0	642,605.2	559,834.3	(27,605.7)	95.3	82,770.8	87.1

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналт, эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх, үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулах зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Дипломат байгууллагуудад үзүүлдэг цогц үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, өрсөлдөх чадвар, мэргэшсэн хамт олныг бий болгон, Монгол улсын гадаад харилцааны салбарт хувь нэмрээ бэхжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Үүнд:

- Үйлчлүүлэгчид үзүүлэх нийтлэг үйлчилгээг олон улсын стандартын түвшинд зохион байгуулж, үйлчилгээний үр ашигтай, чанартай, хямд өртөг зардалтай дэвшилтэт хэлбэрүүдийг сонгож ажиллах;
- Үйлчлүүлэгч байгууллага нь албан ажлын болон тусгай зориулалтын байрны нөхцөл, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ хэвийн ажиллагааг найдвартай хангах, үйл ажиллагаандаа дэвшилтэт техник, технологи шилдэг арга барилыг нэвтрүүлэх;
- Ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, ашигт ажиллагааг тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах замаар өөрийгөө бүрэн санхүүжүүлэх, санхүү нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу хөтлөх;
- Ажиллагсдын сурах, хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч тэднийг эрүүл, аюулгүй орчинд ажиллуулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын болон бусад шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Үйлдвэрийн газар нь чиг үүргээ холбогдох шийдвэр, гэрээ, захиалгын дагуу батлагдсан зардал, норм, стандартын хүрээнд хэрэгжүүлэх;
- Үйлдвэрийн газар нь гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар гэрээний үндсэн дээр зарим төрлийн ёслолын үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн засвар, тохижилт, ашиглалтын болон нийтийн хоол, тээврийн үйлчилгээ үзүүлэх;
- Үйлдвэрийн газар нь эдийн засгийн үр ашиг, мэргэшлийн түвшин, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шаардлага, хүсэлтийг үндэслэн зарим төрлийн үйлчилгээг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гэрээний үндсэн үндсэн дээр гүйцэтгүүлэх;
- Гадаад улс дах Монгол Улсын Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалтыг хариуцаж, бүрэн бүтэн байдлыг хангах талаар зохих арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үзлэг хийх, санал дүгнэлт боловсруулж эрх бүхий байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх;
- Үл хөдлөх хөрөнгийг дипломат статустай болон дипломат статусгүй этгээдэд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр, гэрээний үндсэн дээр түрээслүүлэх;
- Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэх;

#### 3.2 Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд Дипломат байгууллагын

үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд тус ТӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн дарга дотоод аудиторын ажлыг хавсран гүйцэтгэж санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгалт хийж, илэрсэн 5 асуудалд зөвлөмж өгсөн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын захирлын 2020 оны А/160 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн тус үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 650.3 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,099,584.6	1,872,113.2	(1,227,471.4)
Авлага	445,149.8	397,299.3	(47,850.5)
Бусад санхүүгийн хөрөнгө	2,250,000.0	4,000,000.0	1,750,000.0
Бараа материал	569,578.5	602,644.5	33,066.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,460.3	9,650.8	190.5
Үндсэн хөрөнгө	35,402,183.1	34,243,896.1	(1,158,287.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>41,775,956.3</b>	<b>41,125,603.8</b>	<b>(650,352.4)</b>
Өр төлбөр	641,900.9	733,962.1	92,061.2
Эздийн өмчийн дүн	41,134,055.4	40,391,641.8	(742,413.6)
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>41,775,956.3</b>	<b>41,125,603.8</b>	<b>(650,352.4)</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө өмнөх оноос 1,227.5 сая төгрөгөөр буурсан нь 23,895.8 сая төгрөгийн орлого олж, 25,123.3 сая төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэл 397.3 сая төгрөг болж, өмнөх оноос 47.9 сая төгрөгөөр буурсан нь найдваргүй авлагын нөөц 4.8 сая төгрөгөөр, харилцагчаас авах авлага 23.6 сая төгрөгөөр тус тус өсөж, борлуулалтын авлага 1.7 сая төгрөг, татвар, НДШ-ийн

авлага 60.9 сая төгрөг, богино хугацаат авлага 4.0 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой;

- Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 4,000.0 сая төгрөг болж 1,750.0 сая төгрөгөөр өссөн нь хуучин хадгаламжийн гэрээ дуусаж, тайлант онд шинээр Голомт банканд 1 жилийн хугацаатай хадгаламж байршуулсантай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 602.6 сая төгрөг болж, өмнөх оноос 33.1 сая төгрөгөөр буурсан ба тайлант онд 1,111.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,078.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 34,243.9 сая төгрөг болж өмнөх оноос 1,158.3 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 726 дугаар тогтоолоор батлагдсан тус үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 507.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 524 дүгээр тогтоолоор МУ-аас ОХУ-ын Улаан-Үд хотод суугаа консулын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй УАЗ-Фургон машиныг 11.2 сая төгрөгийн үлдэх өртгөөр нь шилжүүлэн авч бүртгэсэн, МУЗГ-ын 2025 оны 90 дүгээр тогтоолоор тус газрын 957.3 сая төгрөгийн балансын үнэтэй 1 дүгээр байр(архивын)-ны барилгыг Гадаад харилцааны яаманд балансаас баланст шилжүүлсэн, тайлант хугацаанд тооцсон 839.8 сая төгрөгийн элэгдлийн зардал зэргээр хөрөнгө буурсантай холбоотой;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 734.0 сая төгрөг болж, өмнөх оноос 92.1 сая төгрөгөөр өссөн нь 1,333.0 сая төгрөгийн татварын өрийг барагдуулж, чанарын баталгааны барьцаа 9.9 сая төгрөг, түрээсийн барьцаа 20.4 сая төгрөгийг тус тус суллаж, урьдчилж орсон 1.1 сая төгрөгийн орлогыг тайлант онд хүлээн зөвшөөрснөөр буурч, барьцаа 112.1 сая төгрөгөөр, татварын өр 1,344.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Эздийн өмчийн дүн 40,391.6 сая төгрөг болж, өмнөх оноос 742.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны цэвэр ашиг 121.4 сая төгрөг, бодлогын өөрчлөлтөөр 459.8 сая төгрөг, зарлагдсан ногдол ашгийн 26.1 сая төгрөг, дахин үнэлгээний 377.8 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 726 дугаар тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 10,455.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,324.5 сая төгрөгөөр, 118.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 627.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 9,920.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,725.3 сая төгрөгийн зардал гарган, 175.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 9,920.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 535.4 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар тасарсан нь ашиглалтын орлого 86.8 сая төгрөг, зоогийн үйлчилгээний орлого 164.9 сая төгрөг, авто баазын орлого 148.7 сая төгрөг, бусад орлого 46.2 сая төгрөг, нийт 446.6 сая төгрөгөөр давж, ЭСЯ-уудын түрээсийн орлого 417.4 сая төгрөг, бусад түрээсийн орлого 564.6 сая төгрөг, нийт 982.0 сая төгрөгөөр тасарсан байна. Тухайлбал,

- ЭСЯ-н түрээсийн орлого 417.4 сая төгрөгөөр тасарсан нь АНУ-ын элчин сайдын яамтай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн шинэчлэл хийгдээгүй, хойшлогдсон;
- Бусад түрээсийн орлого 564.6 сая төгрөгөөр тасарсан нь Оюуны өмчийн газар, Жендерийн үндэсний хороо, Соёлын яам зэрэг байгууллагуудад түрээсийн төлбөр нэмэгдүүлэх тухай өмнө жил нь мэдэгдэж ажилласан боловч төсөвт нэмэлт мөнгө суугаагүй гэдэг шалтгаанаар хуучин дүнгээр төлбөр хийгдсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 9,725.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 599.1 сая төгрөг буюу 5.1 хувиар дутуу байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд нийт 627.0 сая төгрөг батлагдсанаас 3 нэр төрлийн ажилд 558.7 сая төгрөг буюу 89.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Урсгал засварын ажилд 484.1 сая төгрөг төлөвлөснөөс 442.4 сая төгрөг буюу 41.7 сая төгрөг;
- Тоног төхөөрөмж худалдан авахад 124.2 сая төгрөг төлөвлөснөөс 101.8 сая төгрөг буюу 22.4 сая төгрөг;
- Тавилга, эд хогшил худалдан авахад 18.7 сая төгрөг төлөвлөснөөс 14.5 сая төгрөг буюу 4.2 сая төгрөг, нийт 68.3 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 175.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 57.3 сая төгрөгөөр илүү байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5.0 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 29.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 97.6 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 10.2 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 16.9 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 38.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 289.0 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 0.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 118.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 726 дугаар тогтоолоор тайлант онд түрээсийн орлогоос 310.1 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашигт 58.7 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр түрээсийн орлогоос 185.4 сая төгрөг буюу 61.7 хувь, ногдол ашигт 26.1 сая төгрөг буюу 44.5 хувийн тус тус Улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТӨБЗГ-аас Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа орлогыг нэр төрлөөр баталдаг боловч, зардлыг нэр төрлөөр батлаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Программ хангамжийн талаарх судалгаа авахад тус ТӨААТҮГ нь 2023 онд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн 7.1 сая төгрөгийн өртөгтэй нягтлан бодох бүртгэлийн “Fiscus” программ хангамжийг ашиглаж байна.
- Тайлант онд орон тоог 165-аар баталж, 4,263.9 сая төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр удирдах 1, дунд шатны удирдах албан тушаалтан 5, гүйцэтгэх 136 нийт 142 албан хаагчтайгаар 4,258.9 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулжээ.
- Тус ТӨААТҮГ-ын захирлын 2025 оны А/25 дугаар тушаалаар ажилтнуудад ажлын нэг өдрийн хоолны зардалд 11.0 мянган, унааны зардалд 1.0 мянган төгрөгийг тус тус олгож байна. Тайлант онд нийт 361.0 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт, 32.8 сая төгрөгийн унааны хөнгөлөлт, нийт 393.8 сая төгрөгийг олгожээ.
- Гадаад албан томилолтод 41.5 сая төгрөгийн 3 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлээр 34.6 сая төгрөгийг зарцуулсан ба гадаад зочин хүлээн авах зардалд 29.9 сая төгрөгийг төлөвлөсөн боловч арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.
- Ажилтнуудад 4 сургалт зохион байгуулахаар 5.8 сая төгрөгийг төлөвлөж, 5.4 сая төгрөгийг зарцуулжээ.
- Тус ТӨААТҮГ нь 100 хувь төрийн өмчтэй бөгөөд 15,103.8 сая төгрөгийн дүрмийн сантай, 40,391.6 сая төгрөгийн эзний өмчтэй, 121.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөснөөс 3.3 сая төгрөгийн илүү ашигтай байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулахаар зардлын ажил гүйлгээ, төлбөрийн баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Платиниум прогресс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Н.Номин-Эрдэнэ, Э.Туяасайхан нар гүйцэтгэж, компанийн захирал Ж.Баяртуул анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Алтанхуяг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн ДБ01/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 7,917.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 79.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-нь 165 орон тоотойгоор ажиллахаас 142 орон тоотой ажиллаж, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 5.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 625.7 сая төгрөгийн зөрчлөөс 607.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 18.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 157 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: ТӨБЗГ-ын 2024 оны 726 дугаар тогтоолоор баталсан "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг 535.4 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3/-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд Монгал хөгжил ХХК-тай байгуулсан худалдан авалтын гэрээний дүнгээс 7.3 сая төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн, гэрээ байгуулаагүй Гурван шүтээн ХХК, Таван богд ХХК зэргээс нийт 11.0 сая төгрөгийн худалдан авалт хийж, худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуур нийт 18.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.10.1-д "тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн", 49 дүгээр зүйлийн 49.4.4 "худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг төлөвлөсний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 3: Тайлант онд татварын өр өмнөх оноос 38.8 сая төгрөгөөр өссөн ба ААНБОАТ-т 1.6 сая төгрөг, ХХОАТ-т 39.7 сая төгрөг, НӨАТ-т 30.7 сая төгрөг, нийт 71.9 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; МУ-ын ЗГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 28 дугаар хуралдаанаар өгсөн үүргийн 2-т "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлбэл зохих татварын хуримтлагдсан өр төлбөр, татварын ногдлыг 2025 онд багатаан барагдуулахыг төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад" даалгасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд даалгасныг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан асуудлууд нь холбогдох хуулийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хугацаанд Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэж, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 247.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 236.5 сая төгрөгийн 8 албан шаардлага, 10.8 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	8	236,481.1	8	236,481.1	100.0
Зөвлөмж	1	10,848.0	1	10,848.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>247,329.1</b>	<b>9</b>	<b>247,329.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39.3 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 37.3 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.0 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 39.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын төвшнөөс 39.9 сая төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Тайлант онд нийгмийн даатгалын тайланд 29 ажилтны цалин хөлсийг 32.4 сая төгрөгөөр дуутуу, 5 ажилтанд олгоогүй 1.8 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны А-4/469 дугаар албан бичиг, баталсан удирдамжийн дагуу Бүгд найрамдах Чех Улс болон Бүгд найрамдах Польш Улсад хийх төрийн айлчлалын бүрэлдэхүүнд оролцсон удирдлагад гадаад албан томилолтын зардлаас 3,103,860.00 /гурван сая нэг зуун гурван мянга найман зуун жаран/ төгрөгийг зориулалт бусаар олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", гэснийг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны 01 дүгээр сард чөлөөлөгдсөн 2 ажилтанд 02 дугаар сард урьдчилгаа цалин бодож цалингийн зардлаар бүртгэн, ХХОАТ-ын тайланд 2.0 сая төгрөгийн цалин олгосноор тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ын тайланд зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх.

Дээрх аудитын шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант онд нийгмийн даатгалын тайланд 29 ажилтны цалин хөлсийг 32.4 сая төгрөгөөр дутуу, 5 ажилтанд олгоогүй 1.8 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.	1	34,245.8			1	34,245.8						
2	2025 оны 01 дүгээр сард чөлөөлөгдсөн 2 ажилтанд 02 дугаар сард урьдчилгаа цалин бодож цалингийн зардлаар бүртгэн, ХХОАТ-ын тайланд 2.0 сая төгрөгийн цалин олгосноор тайлагнасан байна.	1	1,963.2					1	1,963.2				
3	ТӨБЗГ-аас 2025 оны А-4/469 албан бичгээр МУ-ын ерөнхийлөгч БНЧУ, БНПУ-д хийх төрийн айлчлалын бүрэлдэхүүнд тус ТӨААТҮГ-ын захирал орж ажилласан ба зочид буудлын зардлыг Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан гадаад албан томилолтын зардлын хэмжээнээс 3.1 сая төгрөгөөр илүү төсөвлөж, олгосон байна.	1	3,103.9			1	3,103.9						
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>39,312.9</b>		-	<b>2</b>	<b>37,349.7</b>	<b>1</b>	<b>1,963.2</b>		-	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
1	ТӨБЗГ-ын 2024 оны 726 дугаар тогтоолоор баталсан "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг 535.4 сая төгрөгөөр биелүүлээгүй байна.	1	535,448.8			1	535,448.8		
2	Тус газар Монгал хөгжил ХХК-тай байгуулсан худалдан авалтын гэрээний дүнгээс 7.3 сая төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн, гэрээ байгуулаагүй Гурван шүтээн ХХК, Таван богд ХХК зэргээс нийт 11.0 сая төгрөгийн худалдан авалт хийж, худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуур нийт 18.3 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	18,354.9					1	18,354.9
3	Тайлант онд татварын өр өмнөх оноос 38.8 сая төгрөгөөр өссөн ба ААНБОАТ-т 1.6 сая төгрөг, ХХОАТ-т 39.7 сая төгрөг, НӨАТ-т 30.7 сая төгрөг тус тус өглөгтэй байна.	1	71,898.4			1	71,898.4		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>625,702.1</b>			<b>1</b>	<b>607,347.2</b>	<b>2</b>	<b>18,354.9</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 757/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/24/ИА-СТА-ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны А-4/469 дугаар албан бичиг, баталсан удирдамжийн дагуу Бүгд найрамдах Чех Улс болон Бүгд найрамдах Польш Улсад хийх төрийн айлчлалын бүрэлдэхүүнд оролцсон удирдлагад гадаад албан томилолтын зардлаас 3,103,860.00 /гурван сая нэг зуун гурван мянга найман зуун жаран/ төгрөгийг зориулалт бусаар олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан боох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэснийг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн , 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гадаад албан томилолтын зардлаас зориулалт бусаар олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын захирал Б.Халиун, ерөнхий нягтлан бодогч Ч.Уранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-39.Docx

1526180968



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 756/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/24/НА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 726 дугаар тогтоолоор баталсан "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг 535,448,786.68 (таван зуун гучин таван сая дөрвөн зуун дөчин найман мянга долоон зуун наян зургаан) төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэснийг зөрчиж орлогыг бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн, 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулахдаа орлогын тооцооллыг үндэслэлтэй төлөвлөөгүй, биелүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын захирал Б.Халиун, ерөнхий нягтлан бодогч Ч.Уранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Ж.БАЯРТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 754/A0150079

Улаанбаатар хот

САГ-2026/24/НА - СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийгмийн даатгалын тайланд 29 ажилтны цалин хөлсийг 32,409,385.36 /гучин хоёр сая дөрвөн зуун есөн мянга гурван зуун наян таван/ төгрөгөөр дутуу, 5 ажилтанд олгоогүй 1,836,437.00 /нэг сая найман зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин долоон/ төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн, 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг буруу тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын захирал Б.Халиун, ерөнхий нягтлан бодогч Ч.Уранбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Ж.БАЯРТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 755/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/24/КА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд татварын өр өмнөх оноос 38,856,134.73 (гучин найман сая найман зуун тавин зургаан мянга нэг зуун гучин дөрвөн төгрөг далан гурван мөнгө) төгрөгөөр өссөн ба Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварт 1,557,954.05 (нэг сая таван зуун тавин долоон мянга есөн зуун тавин дөрвөн төгрөг таван мөнгө) төгрөг, Хувь хүний орлогын албан татварт 39,683,646.26 (гучин есөн сая зургаан зуун наян гурван мянга зургаан зуун дөчин зургаан төгрөг хорин зургаан мөнгө) төгрөг, Нэмэгдсэн өртгийн албан татварт 30,656,752.62 (гучин сая зургаан зуун тавин зургаан мянга долоон зуун тавин хоёр төгрөг жаран хоёр мөнгө) төгрөг, нийт 71,898,352.94 (далан нэгэн сая найман зуун ерэн найман мянга гурван зуун тавин хоёр төгрөг ерөн дөрвөн мөнгө) төгрөгийн татварын өртэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах.", Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 28 дугаар хуралдаанаар өгсөн үүргийн 2-т "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлбэл зохих татварын хуримтлагдсан өр төлбөр, татварын ногдлыг 2025 онд багатаан барагдуулахыг төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад" даалгасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-39.Docx

1526180972

1. Төсөвт төвлөрүүлбэл зохих татварын хуримтлагдсан өр төлбөр, татварын ногдлыг 2025 онд багатаан барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дээд газраас улс орны хэмжээнд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨААТҮГ-ын захирал Б.Халиун, ерөнхий нягтлан бодогч Ч.Уранбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

Ж.БАЯРТУУЛ